

туулын эмээж байсан учир хэл хязгаараа хамгаалахад Шигдэн хааны оруулсан зүтгэлтэй үнэлэн шан харамжаа 81 мянган пан хүртэл нэмэгдүүлэхээ амалж байв.¹⁴

Дээр өгүүлсэнийг дүгнэхүүд тухайн үеийн Монголын гадаад харилцаа хязгаарлагдмал байсан бөгөөд гадаад улс төрийн бодлого Монгол-Хятадын хоёр талын харилцаан дээр голлон төвлөрч байв. Монгол-Хятадын харилцаанд Монголын хаад (Аюуширдиар, Эсэн тайш, Батмөнх) нэг үе Хятадын Мин улсыг эзлэн авч дахин ноёрхлоо тогтооход голлон анхаарч байсан бол хожим нь Түмэн засагт хаан, Алтан хан, Лигдэн хааны үед зөвхөн найрамдаж ашигтай худалдаа хийх сонирхол давамгайлж байв. Гэхдээ XIV-XVII зууны бүхий л үед монголчууд аль аль зорилгодоо хүрэхийн тулд хүч хэрэглэх явдлыг гол хэрэгслээ болгож байжээ. Харин Хятадын Мин улс монголчуудыг аль болох нэгдэлгүй тархай байлгах зорилгоор яс хаях, хооронд нь хагалах сонирхол давамгайлж монголчууд нэг үе нэгдэн довтолмоц найрамдаж түр зуур худалдаа хийх замаар амиа аргацааж сүл дорой хамгаалалтын шинж бүхий гадаад бодлого барьж байв. Ер нь өгүүлэн буй үед хоёр улс эрх тэгш харилцаатай байжээ хэмээн дүгнэж болно.

Номзүй:

1. Н.Армигуа "XIV-XVII зууны Монгол-Хятадын харилцаа" УБ., 1996, 9-р тал
2. Мөн тэнд, 10-р тал
3. Henry Settuys. "The Mongols and Ming China: Customs and History" L. 1967, V. pp. 306-307
4. Ibid V. p. 240
5. "XIV-XIX зууны Монголын гадаад харилцаа", УБ., 1997, 18-р тал
6. Мөн тэнд, 26-р тал
7. Ж.Баясах, "Дорно дахины судлалын зарим асуудал", УБ., 1995, 155-р тал
8. Н.Армигуа, Дурдсан зохиол, 31-р тал
9. Ж.Баясах, Дурдсан зохиол, 156-р тал
10. "XIV-XIX зууны Монголын гадаад харилцаа", 37-р тал
11. Мөн тэнд, 40-р тал
12. "Мин Сюацзун шилу /Мин улсын Сюацзун хааны үнэн тэмдэглэл", Сюацзун хааны анхдугаар оны 9-р сарын харгалчин туулай өдөр, Сюацзун хааны 11-р оны 2-р сарын шаргалчин могой өдрийн тэмдэглэл
13. "Мэнгу цзу тунши /Монгол үндэстний товч түүх", 2-р дэвтэр Бээжин, 1991, 612-р тал
14. Д.Покотилова, "История восточных монголов в период династии Мин /1368-1634", Санкт-Петербург, 1893, стр. 216

Ж.Баясах

"XIV-XVII зууны Монголын гадаад харилцаа"

Р.НИКСОН БА ХЯТАД-АМЕРИКИЙН ХАРИЛЦААНЫ ШИНЭ ҮЕ

Доктор (Ph.D) Л.Бээгэжэв
ШУА, Олон Улс Судлалын Хүрээлэн

АНУ-ын 37 дахь ерөнхийлөгч Ричард Милкаус Никсон 1969 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсоныхоо дараа юуны өмнө, түүхэнд мөрөө үлдээх, мөн ерөнхийлөгчөөр дахин сонгогдох үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулсан юм.

1969 оны 1-р сарын 20-нд Р.Никсон ерөнхийлөгчийн албан тушаалд орох үедээ "Бид сөргөлдөөний үе шатны дараа гэрээ хэлэлцээрийн эрин үед орж байна." гэж хэлсэн юм. Р.Никсон гадаад бодлогын хувьд Хятадтай найрсаг харилцаа, тогтоохыг нэн түрүүнд анхаарсан юм. Иймээс ч улс төрийн тавцанд гарсныхаа дараа анхны захирамж нь 1969 оны 2-р сарын 1-нд "Хятадтай холбоо тогтоох бололцоог дахин шинээр эрж хайх тухай" байв.

Хятад-Америкийн харилцааны түүх нь эздрээтэй бөгөөд олон жилийн турш сөргөлдөөнтэй явж ирсэн юм. Хятадын удирдагчид гадаад улс төрийн стратегидаа АНУ, Япон болон Өрнөдийн орнуудыг чухал ач холбогдолтойд ямагт үздэг байв. Бүр БНХАУ байгуулагдахаас өмнө 1944 оны 8-р сарын 23-нд Мао Зэдун Яньваньд АНУ-ын элчин сайдын яамны төлөөлөгч Жон Сервис-тэй ярилцахдаа: "Хятад-Америкийн эрх ашиг хоорондоо холбоотой адил төстэй байна. Энэ хоёр улс улс төрийн талаар ч, эдийн засгийн талаар ч таарч тохирч байна. Бид хамт ажиллаж чадна. Тэгэх ч ёстой"² гэж мэдэгдэж байв. Гэвч тодорхой нөхцөл байдлын улмаас Хятад-АНУ-ын харилцаа 70-аад оны эхэн хүртэл сөргөлдөөнтэй хэвээр байв. Р.Никсон БНХАУ-тай харилцах АНУ-ын шинэ бодлогыг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Энэ чиглэлээр нэлээд олон шийдвэрийг Р.Никсон өөрөө санаачлан гаргаж байлаа. 1970 оны 10-р сард Р.Никсон Хятад-Америкийн харилцааг мухардмал байдлаас гаргах санаагаа илэрхийлж "Хэрэв би үхэхээсээ өмнө ямар нэгэн хэрэг үйлс хийх хэрэгтэй гэвэл энэ нь хятадад очих явдал юм. Би очиж чадахгүй байлаа ч миний үр хүүхдүүд очих хэрэгтэй"³ гэж хэлж байлаа. Тэрээр НҮБ-ын 25 жилгийн ойн арга хэмжээнд оролцохоор очсон Пакистаны

Л.Бээгэжэв

"Р.Никсон Ба Хятад-Америкийн харилцааны шинэ үе"

ерөнхийлөгч Яхья-Хан, Румыны ерөнхийлөгч Н. Чаушеский нарт хандан хятадын удирдагчидтай уулзахад зуучлахыг хүсэлт болгожээ. "Хятад-Америкийн харилцаа маш чухал бөгөөд Хятадтай найрсаг харилцаатай байх хэрэгтэй, АНУ ЗХУ-тай хамтарч Хятадын эсрэг хэзээ ч зогсохгүй" гэдгийг Р. Никсон илэрхийлээд дээд хэмжээний элч төлөөлөгчийг нууцаар хятадад айлчуулахыг хүсч байгаагаа Пакистан, Румыны ерөнхийлөгч нарт нэгэн адил хүссэн байна. Мөн оны 10-р сарын 26-ны өдөр Р. Никсон анх удаагаа "БНХАУ" гэсэн албан ёсны нэрийг хэрэглэснийг өрнөдийнхөн "Түн гүнзгий дипломат бодлогын илэрхийлэл гэж нэрлэж байв". Удалгүй Яхья-Хан Хятадад айлчилж Р. Никсоны санаа бодлыг Хятадын удирдагчдад уламжилсан юм. 1970 оны 11-р сарын сүүлээр Румыны дэд ерөнхийлөгч Хятадад айлчлахдаа Никсоны хүсэлтийг нэгэн адил уламжилсан байна. Хятадын тал Америкийн мэдээг хүлээж авсны дараа Мао Зэдун Хятад-Америкийн асуудлыг шийдвэрлэх Америкийн эрх баригчидтай яриа хэлэлцээр хийхэд бэлтгэх заалт өгчээ. Мао Зэдун 1970 оны 12-р сарын 18-нд Америкийн сэтгүүлч Сноу-тай уулзахдаа "Хэрвээ Р. Никсон Хятадад ирэхийг хүсвэл би түүнтэй ярилцахыг хүсч байна. Яриа амжилттай ч болж болно, амжилтгүй ч байж болно, хэрэлдэж ч болно хэрэлдэхгүй ч бас болно. Тэрээр жуулчны хувиар ч ирж болно, мөн ерөнхийлөгчийн хувиар ч ирж болно. Товчоор хэлбэл, бүгд болно. Би үзэхдээ түүнтэй хэрэлдэж чадахгүй, шүүмжлэх хэрэгтэй бол түүнийг шүүмжилнэ" гэж хэлжээ.

1971 оны 2-р сард Р. Никсон АНУ-ын Конгресст гадаад бодлогын асуудлаар үг хэлэхдээ "Америк-Хятадын ард түмний хооронд өргөнөөр харилцах боломжийг бий болгох, улмаар энэ боломжийг бодитой, хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг яаж арилгахыг би нарийн судлах хэрэгтэй байна" гээд "Бид хийж чадах л бүх зүйлээ заавал хийнэ" гэжээ.

1971 оны 4-р сард Японд болсон одон бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах 31-р тэмцээнд оролцсон АНУ-ын баг тамирчдыг Мао Зэдун Хятадад айлчлахыг урьсан юм. Р. Никсон үүнийг нэн даруй зөвшөөрчээ. Хятадын ерөнхий сайд Жоу-Эньлай Америкийн тамирчдыг хүлээн авч уулахаадаа: "Та нар энэ удаа урилгаар Хятадад айлчилж хоёр орны ард түмний найрсаг харилцааны үүдийг нээлээ. Бид Хятад-Америкийн хоёр орны ард

түмний найрсаг харилцааг хоёр орны ард түмний дийлэнхи нь сайшаан дэмжинэ гэдэгт итгэж байна" хэлсэн юм. Энэ нь "Одон бөмбөгийн дипломат бодлого", (Пинг-Понг-ийн дипломат бодлого) гэж алдаршиж дэлхийг шуугиулсан билээ. Улс төрийн ажиглагчид "жижигхэн бөмбөг том ертөнцийг эргүүлээ" гэж энэ үйл явдлыг дүгнэж байсан бөгөөд энэ бодлого нь Хятад-Америкийн харилцаа ба дэлхийн бодлогын өөрчлөлт хөгжилтөд түлхэц үзүүлэв.

Р. Никсоны Хятадтай харилцах бодлогыг Г. Киссинжер гардан хэрэгжүүлж байлаа. Хятад-Америк хоёр орны стратегийн санаархал харилцан ил болсны дараа Хятадын ерөнхий сайд Жоу-Эньлай 1971 оны 4-р сарын 21-нд Пакистаны ерөнхийлөгчөөр дамжуулж Америкийн талд явуулсан урилганддаа "Хятад-Америкийн хоёр орны харилцааг үндсээр нь сэргээх хэрэгтэй байна. Хятадын Тайвань ба Тайваний эргийн бүс нутгаас Америкийн бүхий л зэвсэгт хүчнийг гаргах ёстой, улмаар энэ гол асуудлыг зөвхөн дээд хэмжээний удирдагчдын шууд яриа хэлэлцээрээр дамжуулбал сая шийдвэрлэх арга замыг олж болох юм. Иймээс Хятадын Засгийн газар Америкийн ерөнхийлөгчийн тусгай элч, тухайлбал доктор Киссинжер буюу ерөнхийлөгч Р. Никсонтой Бээжинд шууд гэрээ хэлэлцээр хийхийг хүсч байгаага мэдэгдэж байв.

Хятадын тал 5-р сарын 31-нд Яхья-Хан-аар дамжуулж Мао Зэдун, Р. Никсон нарын уулзалт хийхэд бэлтгэж байгаагаа илтгэсэн байна. Р. Никсон энэхүү урилгыг хүлээж аваад сэтгэл нь нэн хөдөлж "Энэ бол дэлхийн 2-р дайнаас хойш Америкийн ерөнхийлөгч нарын хүлээж авсан бүх л баримт бичгийн дотроос хамгийн чухал нь юм" гэж тэмдэглэжээ.

1971 оны 7-р сарын 9-нөөс 11-нд АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын хэрэг эрхэлсэн туслах доктор Киссинжер Хятадад айлчлан 48 цаг болохдоо ерөнхий сайд Жоу-Эньлайтай 17 цаг гаруй хэлэлцээр хийж Р. Никсоны Хятадад айлчлах хугацаа, бэлтгэл ажлын тухай хэлэлцээ хийв. Хятадын ерөнхий сайд Жоу-Эньлай Р. Никсоныг 1972 оны 5-р сараас өмнө тохиромжтой цагтаа Хятадад айлчлах тухай БНХАУ-ын Засгийн газрын урилгыг Киссенжер гардуулжээ. Р. Никсон урилгыг талархан хүлээж авчээ. Ингээд Р. Никсон 1972 оны 2-р сарын 21-нээс 28-нд Хятадад айлчлав. АНУ-ын ерөнхийлөгчийг дагалдан төрийн нарийн бичгийн

дарга У.Рожерс ерөнхийлөгчийн үндэсний аюулгүй байдлын туслах Г.Киссинжер нарын албаны хүмүүс хамт ирсэн байна. Мао Зэдүн Р.Никсоныг хүлээн авч уулзаж хэлэлцээ хийсний дараа гаргасан хамтарсан албан мэдээнд тэмдэглэснээр "хоёр орны удирдагчид олон улсын болон Хятад-Америкийн харилцааны асуудлаар нухацтай, илэн далангүй" ярилцсан байна. Хятад-Америкийн дээд хэмжээний уулзалтыг албан ёсоор тэмдэглэсэн цорын ганц нийтлэгдсэн баримт бичиг бол 1972 оны 2-р сарын 27-ны өдрийн хамтарсан албан мэдээ юм.⁸ Шанхайн албан мэдээ гэж нэрлэгдсэн энэ баримт бичигт:

- БНХАУ-ын Засгийн газар бол Хятадын хууль ёсны цорын ганц Засгийн газар мөн.

- Тайвань бол Хятадын салшгүй нэг хэсэг мөн.

- Тайванийг чөлөөлөх нь Хятадын дотоод хэрэг мөн бөгөөд бусад ямар ч тал түүнд хөндлөнгөөс оролцох эрхгүй гэдгийг дурьдсан байна. Хятадын ерөнхий сайд Жоу-Эньлайг уг айлчлалыг "Хятад, АНУ-ын хоорондын харилцааны түүхэнд гарсан маш том үйл явдал мөн" гэж үнэлсэн юм.

Р.Никсон Хятадад хийсэн айлчлалынхаа үр дүнг дүгнэж: "Энэ долоо хоног бүх ертөнцийг өөрчиллөө өнөөдөр манай хоёр ард түмэн бүх дэлхийн ирээдүйг гартаа атгаж байна"⁹ гэж тэмдэглэжээ. Р.Никсон БНХАУ-д айлчилсан нь Хятад-Америкийн харилцаанд шинэ үе шат болсон юм. Р.Никсоны айлчлалыг Харвардын их сургуулийн Дорнод азийн орнуудыг судлах төвийн захирал Ж.Фэрбенк үнэлэн: "Хятад-Зөвлөлтийн хооронд хагарал гарсан үеэс хойш АНУ-ын хийсэн цорын ганц зүй ёсны ажиглалтаа мөн"¹⁰ гэжээ. Мөн З.Бжезинский: Р.Никсоны айлчлал нь

НЭГДҮГЭЭРТ: Америкийн сонгогчдод нөлөө үзүүлэх явдал.

Хоёрдугаарт, Москвад нөлөө үзүүлэх явдал бөгөөд энэ утгаараа ХХ зууны төрийн хамгийн чухал айлчлал болох нь магадгүй гэж бичжээ.

Р.Никсоны Хятадад айлчлах шийдвэр гаргасан нь түүний нэр хүндийг ихээхэн дээшлүүлсэн бөгөөд энэ ч утгаараа Америкийн түүхэнд хүндтэй байр эзлэх түүхэн үйл явдлын эхийг тавьсан юм. АНУ, БНХАУ-ын харилцаа хэвийн болгох үйл явц Р.Никсоны Хятадад хийсэн айлчлалын дараа шинэ үе шатандаа орсон байна. Ийнхүү Хятад-Америкийн харилцааг хэвийн болгох үйл явц

АЛТАН АРГАМЖ

Р.Никсоны айлчлалаас хойш хоёр талын долоон жил гаруй үргэлжилсэн яриа хэлэлцээрийн үр дүнд 1978 оны 12-р сарын 15-нд дуусаж 1979 оны 1-р сарын 1-нээс эхлэн албан ёсны дипломат харилцаа тогтоосон юм.¹² Дэлхийн хоёр том гүрэн болох АНУ БНХАУ-ын харилцааны шинэ үеийг нээхэд ерөнхийлөгч Р.Никсоны холын хараатай бодлого чухал үүрэг гүйцэтгэж өөрийнхөө хүссэнээр түүхэнд нэрээ мөнхөлж, ерөнхийлөгчөөр дахин сонгогдох хүслээ биелүүлсэн юм.

Гэвч тэрээр сөрөг хүчнийхээ үйл ажиллагааг дэлдүүр чягнасан хэрэгт холбогдож АНУ-ын түүхэнд хугацаанаасаа өмнө өөрөө огцорсон анхны ерөнхийлөгч болсон юм.

Ишлэл зүүлт:

1. The Foreign Policy Association Headline Series N 234, The Debate Over Detente, New York, 1977, February, p. 10-11
2. The Amerasia Papers: Aclue to the catastrophe of China, vol. 1970, p. 796
3. "Life", 1971, July 30.
4. "Шинэ Хятадын гадаад бодлогын байдал" 2-р дэвтэр. Бээжин. 1991. 33-45 тал.
5. Мөн дурьдсан зохиол. 36-р тал.
6. Мөн дурьдсан зохиол. 38-р тал
7. "Жэнь минь жибэо" 1972.2.22
8. "Жэнь минь жибэо" 1972.2.28
9. "The New York Times", Febr. 28, 1972.
10. "The Christian Science Monitor" July 17, 1976
11. "News Week", 1972, Febr. 14, p. 46
12. "Жэнь минь жибэо" 1978. 12. 15